## ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
## ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**Өвөрхангай аймгийн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцын тайлан**






# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2018 ОНЫ ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТТАЙ, ТЕЗ-ДЫН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨР НЬ ХҮРЭХ ҮР ДҮН ЗОРИЛТОТ ТҮВШИНД НИЙЦЭЖ, ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖ БАЙНА.

**САГ-2018/02-СА** **2018 оны 11 дүгээр сар**

# АГУУЛГА


ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Тэргүүлэх аудитор (Л.Ламаачин)

Аудитын менежер (Д.Гансүх)

Аудитор (Б.Эрдэнэцэцэг) (Д.Нарантуяа)


2018 оны 11 дүгээр сар

*Уг тайланг АГ-ын Uvurkhangai_audit@audit.gov.mn Fasebook хаягаар орж үзнэ үү.*

*Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70323108 дугаарын утас,70323253 дугаарын факсаар харилцана уу*

*ХАЯГ: (Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон 402 тоот)*


- Товчилсон үгийн тайлбар
- Ерөнхий зүйл
- Үндсэн мэдээлэл

БҮЛЭГ-1: 2018 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

**1.1 Өвөрхангай аймгийн 2018 оны төсөв нь төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлт болон бусад шалгууртай нийцсэн байна.**

**1.2 Өвөрхангай аймгийн 2018 оны төсвийн төлөвлөлтийг өмнөх оны гүйцэтгэл болон тухайн нөхцөл байдлын зайлшгүй шаардлагатай уялдуулж үзээд, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого дутуу төлөвлөгдсөн, бусад орлого болон зарлагын төлөвлөлт зохистой байна гэж үзлээ.**

БҮЛЭГ-2: 2018 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БҮРЭН ХЭРЭГЖИХ БОЛОМЖТОЙ БАЙНА.

**2.1 Аймгийн төсвийн 2018 оны нийт орлого ба тусламжийн төлөвлөгөө бүрэн хэрэгжих боломжтой байна.**

**2.2 Төсөвт болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудад 9.0 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх боломж байна.**

БҮЛЭГ-3: 2018 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ, ХЭМНЭЛТТЭЙ, ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛЖ БАЙНА.

**3.1 2018 оны төсвийг зардлын зүйл анги тус бүрээр хэмнэлттэй зарцуулж байна.**

**3.2 Төсвийг зарцуулахдаа Төсвийн болон ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлж байна.**

БҮЛЭГ-4: ТЕЗ-ДЫН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨР НЬ ХҮРЭХ ҮР ДҮН ЗОРИЛТОТ ТҮВШИНД НИЙЦЭЖ, ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖ БАЙНА.

**4.1 ТЕЗ-дын хэрэгжүүлж буй хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлт зохистой байна.**

**4.2 ТЕЗ-д 2018 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж, төсвийг зориулалтын дагуу зарцуулж байна.**

**4.3 Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалттай байна.**

- ДҮГНЭЛТ
- ЗӨВЛӨМЖ

# ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| ҮАГ | Үндэсний Аудитын газар |
| САГ | Санхүүгийн аудитын газар |
| УИХ | Улсын их хурал |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ИТХТ | Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| СХС | Сум хөгжүүлэх сан |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ОНӨҮГ | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ЗГ | Засгийн газар |
| МУ | Монгол улс |
| ААН | Аж ахуй нэгж |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин |
| ХХЭрхлэгч | Хувиараа хөдөлмөр эрхлэгч |
| ОН | Орон нутаг |
| НД | Нийгмийн даатгал |
| ЭМД | Эрүүл мэндийн даатгал |
| ТБОНӨХБАҮХА | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ЗГХЭГ | Засгийн газрын хэрэг эрхлэх газар |
| СТСХ | Санхүү төрийн сангийн хэлтэс |

## Ерөнхий зүйл

**Аудитын нэр:** 2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц
**Аудитын код:** САГ-2018/02-СА
**Аудитын хийх үндэслэл:**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтын бүрэн эрхийн хүрээнд, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, Монгол Улсын Ерөнхий аудиторт аймгийн Аудитын газраас нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Өвөрхангай аймгийн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад аудитыг хийж гүйцэтгэв.

**Аудитын зорилт:**

2018 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сан болон Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулиудын хэрэгжилтийн явцыг шалгаж, дүгнэлт гарган ҮАГазар болон орон нутагт танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх.
- 2018 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх.
- 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй, зарцуулж буй эсэх.
- ТЕЗ-ын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх

**Хамрах хүрээ:**

Аудитаар орон нутгийн төсөв, улсын төсвийн санхүүжилт, төсвийн орлого бүрдүүлж байгаа байгууллага, 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан аудитыг хийлээ.

**Аудитын арга зүй:**

Аудитыг явуулахдаа Аудитын олон улсын стандарт, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан, орлого болон зардлын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, холбогдох хүмүүсээс асууж тодруулах, тайлбар авах, тулган шалгах, дахин тооцоолох зэрэг арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.

Аудитын олон улсын стандарт, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

**Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- ✓ Монгол Улсын Үндсэн хууль
- ✓ Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- ✓ Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль
- ✓ Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль
- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ✓ Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, аймгийн ИТХ, Засаг даргын захирамж, бусад эрхийн актууд

***Аудитын стандартын талаарх мэдэгдэл:***

Энэхүү аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитыг Өвөрхангай аймгийн Аудитын газрын аудитор Б.Эрдэнэцэцэг, Д.Нарантуяа нар 2018 оны 09 дүгээр сарын 17-ноос 11 дүгээр сарын 04-ний өдрүүдэд хийж гүйцэтгэв.

**Үндсэн мэдээлэл.**

Сангийн яамнаас Өвөрхангай аймгийн 2018 оны төсвийн суурь орлогыг 9821.2 сая төгрөгөөр, суурь зарлагыг 23945.0 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэгийг 14123.7 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийг 45706.5 сая төгрөгөөр, аймгийн ОНХСанд олгох орлогын шилжүүлгийг 536.4 сая төгрөгөөр хянасан байна.

Аймгийн төсөвт орох татварын болон татварын бус орлогыг 8264.1 сая төгрөгөөр төлөвлөж эхний 9 сарын гүйцэтгэлээр 8204.2 сая төгрөг оруулж орлогын төлөвлөгөөний биелэлт 99.2 хувийн биелэлттэй.

Сумын төсөвт орох татварын орлогоор 3199.5 сая төгрөг оруулахаас эхний 9 сарын гүйцэтгэлээр 2928.4 сая төгрөг оруулж 91.5 хувийн биелэлттэй байна.

Орон нутгийн төсөвт орсон нийт татварын орлогын 73.6 хувийг аймгийн төсөвт, 26.4 хувийг сумын төсөвт оруулсан байна.

## БҮЛЭГ 1. 2018 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

### 1.1. Өвөрхангай аймгийн 2018 оны төсөв нь төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлт болон бусад шалгууртай нийцсэн байна.

Төсвийн төслийг боловсруулах, батлах харилцааг Төсвийн тогтвортой байдлын тухай болон Төсвийн тухай хуулиар зохицуулж байна. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3-т заасны дагуу 2018 оны төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээ 2017 оны 08 дугаар сарын 11-нд Сангийн яаманд хүргүүлсэн байна.

2018 оны төсвөө боловсруулахдаа дараах хэд хэдэн зарчмыг баримталжээ.

- ЗГ-ын 2017 оны 188 дугаар тогтоолоор батлагдсан ТЕЗ нарын 2018 оны төсвийн хязгаарыг баримтлах, хэтрүүлэхгүй байх.
- Зарлагыг аль болох бууруулах, өсөлтийг хязгаарлах
- Төсвийн үр ашгийг сайжруулах, хэмнэлтийн горимд шилжүүлэхтэй холбоотой УИХ, ЗГ-аас баталсан тогтоол шийдвэрүүдийг мөрдөх.
- Бүтцийн өөрчлөлт, бусад шийдвэрээр орон тоо, урсгал зардал нэмэгдүүлэхгүй байх.
- 2017 онд хэрэгжиж дуусах болон тухайн онд хэрэгжсэн нэг удаагийн шинжтэй хөтөлбөр арга хэмжээний зардлыг бууруулж тооцох.

Дээрх зарчмыг баримталсан ч зарим зардлуудыг орон нутгийн тухайн жилийн онцлог үйл явдалтай уялдуулж нэмэгдүүлж төлөвлөжээ. Тухайлбал: МУ-ын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай хуулиуд болон ЗГ-ын тогтоол, байгууллагын дотоод журмыг тус тус үндэслэн 2018 онд тэтгэвэрт гарах нас болсон төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын тэтгэмжийн зардлыг 177.6 сая төгрөг, Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн шийдвэрээр 1м3 халаалтын үнэ 10 хувиар нэмэгдсэн, 2017 оны 10 дугаар сараас ахмадын өргөө ашиглалтад орохтой холбоотой урсгал зардлыг 64.8 сая төгрөг, сүүлийн жилүүдэд малын гоц халдварт өвчний дэгдэлт ихсэж байгаатай холбоотой мал эмнэлгийн үйлчилгээний зардал 409.0 сая төгрөг зэргээр

нэмэгдүүлж, холбогдох судалгаа шинжилгээ, баримт материалыг тайлбарын хамт хүргүүлжээ.

**1.2. Өвөрхангай аймгийн 2018 оны төсвийн төлөвлөлтийг өмнөх оны гүйцэтгэл болон тухайн нөхцөл байдлын зайлшгүй шаардлагатай уялдуулж үзэхэд аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого дутуу төлөвлөгдсөн, бусад орлого зарлагын төлөвлөлт зохистой байна.**

- **Орлогын төлөвлөлтийн талаар.**

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний “Аймгийн 2017 оны төсөв батлах тухай“ 06/08 дугаар тогтоолоор аймгийн төсвийн татварын болон татварын бус орлогыг 8264.1 сая төгрөгөөр баталжээ. Анх баталсан төлөвлөгөөнд өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт №1 /сая төгрөгөөр/

| д/д | Орлогын нэр төрөл | 2016 оны гүйцэтгэл | 2017 оны гүйцэтгэл | 2018 оны төлөвлөгөө | зөрүү |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Аймгийн төсвийн орлого бүгд** | **8427.6** | **9221.7** | **8264.1** | **-957.6** |
| **2** | **Аймгийн төсвийн татварын орлого** | **7570.4** | **8513.7** | **7908.9** | **-604.8** |
| **2.1** | Газрын төлбөр | 120.7 | 109.1 | 135.0 | 25.9 |
| **2.2** | Үл хөдлөх хөрөнгийн албан татвар | 306.3 | 328.9 | 320.0 | -8.9 |
| **2.3** | Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 459.0 | 512.8 | 510.0 | -2.8 |
| **2.4** | Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр | 303.0 | 438.8 | 349.6 | -89.2 |
| **2.5** | Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвар | 6320.0 | 6991.6 | 6446.4 | -545.2 |
| **2.6** | Улсын тэмдэгтийн хураамж | 61.4 | 132.5 | 148.0 | 15.5 |
| **3** | **Аймгийн төсвийн татварын бус орлого** | **857.2** | **708.0** | **355.1** | **-352.9** |
| **3.1** | Хүү, торгуулийн орлого | 303.1 | 647.3 | 340.1 | -307.2 |
| **3.2** | Бусад орлого | 538.2 | 44.7 | 0 | -44.7 |
| **3.3** | Орон нутгийн өмчийн оролцоотой Баянтээг ХК-ны ногдол ашиг | 15.9 | 16.0 | 15.0 | -1 |

График №1




Өмнөх хоёр оны орлогын гүйцэтгэл жилээс жилд өсөлттэй байхад 2018 оны төлөвлөгөөг 2017 оны гүйцэтгэлээс 957.6 сая төгрөгөөр бууруулж баталсан нь аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөг дутуу төлөвлөсөн гэж үзэж байна. Өмнөх жилүүдийн төлөвлөлтөөс харахад төсвийг анх батлахдаа багаар батлаад орлого нэмэгдэхийн хэрээр түүнийг зарцуулахаар ИТХ-аар төсвийг хэд хэдэн удаа тодотгож баталж ирсэн байна.

Аймгийн нийгэм эдийн засгийн цар хүрээ жилээс жилд өргөжин тэлж, татварын бааз суурь нэмэгдэж байгаатай уялдуулан төвлөрөх орлогын хэмжээ, нөөц боломжийг бүрэн судалж анхнаасаа зөв төлөвлөх нь зүйтэй.

**Сумын орлогын төлөвлөлтийн талаар.**

Хүснэгт №2 /сая төгрөгөөр/

| д/д | Орлогын нэр төрөл | 2017 оны гүйцэтгэл | 2018 оны батлагдсан төсөв | Өсөлт/бууралт |
|---|---|---|---|---|
| **1** | **Сумын татварын орлогын дүн** | **1808.8** | **3199.5** | **+1390.7** |
| 1.1 | Үйл ажиллагааны орлого /Аж ахуй эрхэлсний орлого | 654.9 | 696.9 | 42.0 |
| 1.2 | Хөрөнгийн орлого | | 881.8 | 881.8 |
| 1.3 | Хөрөнгө борлуулсны орлого | 83.6 | 85.0 | 1.4 |
| 1.4 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар | 108.8 | | -108.8 |
| 1.5 | Улсын тэмдэгтийн хураамж | 119.4 | 138.7 | 19.3 |
| 1.6 | Бууны албан татвар | 45.2 | 60.6 | 15.4 |
| 1.7 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 34.2 | 36.8 | 2.6 |
| 1.8 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 493.5 | 521.1 | 27.6 |
| 1.9 | Ургамал ашигласны төлбөр | | | |
| 1.10 | Ойн нөөц ашигласны төлбөр | 606.8 | 152.5 | -454.3 |
| 1.11 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 269.5 | 259.2 | -10.3 |
| 1.12 | Ус ашигласны төлбөр | 7.3 | 4.5 | -2.8 |
| 1.13 | Бусад татвар | 83.7 | | -83.7 |
| 1.14 | Нохойн татвар | 2.6 | 8.5 | 5.9 |
| 1.15 | Торгуулийн орлого | 433.3 | 350.8 | -82.5 |
| 1.16 | хүүгийн орлого | | 3.0 | 3 |

Сумын татварын орлогын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд нийт дүнгээр 1390,7 сая төгрөгөөр илүү төлөвлөгдсөн ч торгуулийн орлого 82.5 сая төгрөг, ус ашигласны төлбөр 2.8 сая төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөр 10.3 сая төгрөг, ойн нөөцийн төлбөр 454.3 сая төгрөгөөр тус тус буурч батлагджээ.

Буурсан шалтгаан нь: Ойн нөөцийн төлбөр хангайн сумдын самрын орлоготой уялдаж батлагддаг учир энэ онд тус орлого бүрдэх боломжгүй болсон. Торгуулийн орлого өмнөх жилд зарим сумдын нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан зөрчилтэй ААН-үүдтэй холбоотой орлого давж биелж байсан учир үүнийг бодит гүйцэтгэлээс бууруулж баталжээ. Ангийн нөөцийн төлбөрийн хувьд тухайн сумаас шалтгаалахгүйгээр агнах ангийн тоог эрх бүхий дээд байгууллагаас тогтоож өгдөг байна.

Сумын орлогын 2018 оны төлөвлөлт өмнөх оны гүйцэтгэлээс эрс өссөн гол шалтгаан нь хадгаламжийн хүүгийн орлогод татвар ногдуулах тухай хуулийн зохицуулалт хийгдсэнтэй холбоотой байна.

**Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлогын төлөвлөлтийн талаар.**

Хүснэгт № 3 /сая төгрөгөөр/

| | Орлогын төрөл | 2017 оны гүйцэтгэл | 2018 оны төлөвлөгөө | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **4** | **Төвлөрүүлэх орлого бүгд** | **64565.1** | **67394.3** | **2829.2** |
| 4.1 | Төсөвт байгууллагын үйл ажиллагаа, СХС-ийн зээл, урьд оны үлдэгдлээс санхүүжих | 4655.5 | 3189.9 | -1465.6 |
| 4.2 | Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг | 12415.7 | 14123.7 | 1708.0 |
| 4.3 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийн санд олгох орлого | 2253.9 | 4374.2 | 2120.3 |
| 4.4 | Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг | 45240.0 | 45706.5 | 466.5 |

Дээрх орлогуудыг төлөвлөхдөө 2017 оны гүйцэтгэлийг үзүүлэлт болгож, орлогын эх үүсвэрийг нэр төрлөөр төлөвлөжээ.

➢ **Аймгийн төсвийн зарлагын төлөвлөлтийн талаар.**

Хүснэгт №4 /сая төгрөгөөр/

| | Төсвийн зарлага | 2017 оны Гүйцэтгэл | 2018 оны төлөвлөлт | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 32797.4 | 34538.6 | 1741.2 |
| 2 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 3607.7 | 4177.3 | 569.6 |
| 3 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5433.3 | 6689.8 | 1256.5 |
| 4 | Хангамж, бараа материалын зардал | 1293.0 | 1214.5 | -78.5 |
| 5 | Нормативт зардал | 3283.5 | 3284.7 | 2.0 |
| 6 | Эд хогшил, урсгал засварын зардал | 960.3 | 505.1 | -455.2 |
| 7 | Томилолт, зочны зардал | 230.2 | 209.3 | -20.9 |
| 8 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1512.3 | 1475.8 | -36.5 |
| 9 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2840.8 | 2299.8 | -541.0 |
| 10 | Татаас | 116.1 | 260.7 | 144.6 |
| 11 | Урсгал шилжүүлэг | 15673.1 | 13872.6 | -1800.3 |
| 12 | Хөрөнгийн зардал | 4553.9 | 7196.4 | 2642.5 |
| 13 | Эргэн төлөгдөх зээл | 2173.8 | 3133.3 | 959.5 |
| | **Нийт зардлын дүн** | **74474.8** | **78857.9** | **4383.1** |

Нэг удаагийн тэтгэмж урамшуулал дээр батлагдаж ирсэн гурван зуун мянган төгрөгийг цалингийн зардалд тусгаж өгсөн, шинээр ашиглалтад орсон төсөвт байгууллагуудын орон тоотой холбоотой цалин шимтгэлийн зардал өмнөх оны гүйцэтгэлээс нэмэгдэж батлагдсан байна.

Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу халаалтын зардал 10 хувиар нэмэгдсэн.

Сангийн яамнаас орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлж өгснөөр хөрөнгийн зардал 2642.5 сая төгрөгөөр нэмэгджээ.

Бусад зардлуудыг өмнөх оны гүйцэтгэлээс бууруулж баталсан байна.

2018 оны Төсвийн тухай хуулиар Өвөрхангай аймагт улсын төсвийн хөрөнгөөр 58 төсөл арга хэмжээ, барилга байгууламжид 31671.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 06/08 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 12 төсөл арга хэмжээ, барилга байгууламжид 2745.0 сая төгрөгийн санхүүжилт, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 5 төсөл арга хэмжээнд 1944,1 сая төгрөгийн санхүүжилт, автозамын сангийн хөрөнгө оруулалтын 4 төсөл арга хэмжээнд 463.4 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус баталсан байна.

Мөн аймгийн ИТХ-ын 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 07/03 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 18 төсөл арга хэмжээнд 1443.0 сая төгрөгийн санхүүжилт нэмж баталсан байна.

➢ **Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сангийн орлого зарлагын төсвийн төлөвлөлтийн талаар**

Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн орлогыг анх батлахдаа 18053.8 сая төгрөгөөр, зарлагыг 60916.5 сая төгрөгөөр тус тус баталжээ. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс 2018 оны 06 дугаар сард төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж зарлагыг 42.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталжээ.

Орлого зарлагын төлөвлөлтийг даатгалын төрлөөр харуулбал:

Хүснэгт №5 /сая төгрөгөөр/

| № | Нийгмийн даатгалын сангийн төсөв | Орлого | | | Зарлага | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Анх батлагдсан | Тодотгосон төсөв | Зөрүү | Анх батлагдсан | Тодотгосон төсөв | Зөрүү |
| 1 | Тэтгэврийн даатгалын сан | 14889.7 | 14889.7 | | 57659.0 | 57659.0 | 0 |
| 2 | Тэтгэмжийн даатгалын сан | 1606.1 | 1606.1 | | 2027.0 | 2030.7 | 3.7 |
| 3 | ҮОМШӨ-ний даатгалын сан | 1165.9 | 1165.9 | | 696.9 | 735.2 | 38.3 |
| 4 | Ажилгүйдлийн даатгалын сан | 392.1 | 392.1 | | 533.6 | 534.4 | 0.8 |
| | **Дүн** | **18053.8** | **18053.8** | **0** | **60916.5** | **60959.3** | **42.8** |

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн орлогыг 3838.5 сая төгрөгөөр, зарлагыг 9202.1 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна. ЭМД-ын сангийн орлого зарлагын төлөвлөлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6 /сая төгрөгөөр/

| № | Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв | Орлого | | | Зарлага | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эх үүсвэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл 09.30 | хувь | Зарцуулалтын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл 9.30 | Хувь |
| 1 | Ажил олгогч, даатгуулагчаас төлөх | 3166.4 | 2973.9 | 94% | Төрийн өмчийн эмнэлэг | 4284.8 | 3281.5 | 76.5% |
| 2 | ХХЭрхлэгч иргэн, малчин суралцагсад | 671.6 | 565.6 | 84% | Хувийн эмнэлэг | 1157.8 | 507.4 | 43.8% |
| 3 | Бусад орлого | 0.5 | 0.5 | 100% | Рашаан сувилал | 2833.2 | 1923.3 | 67.8% |
| | | | | | Эмийн сан | 926.2 | 670.2 | 72.3% |
| | **Дүн** | **3838.5** | **3540.1** | **92.2%** | | **9202.0** | **6382.4** | **69.3%** |

**1.3 Монгол улсын 2018 оны нэгдсэн төсвийн алдагдал, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийг бодитой тооцоолсон асуудал орон нутагт байхгүй болно.**

## БҮЛЭГ 2. 2018 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БҮРЭН ХЭРЭГЖИХ БОЛОМЖТОЙ БАЙНА.

**2.1 Аймгийн төсвийн 2018 оны нийт орлого ба тусламжийн төлөвлөгөө бүрэн хэрэгжих боломжтой байна.**

2018 оны аймгийн төсвийн орлого нийт дүнгээрээ 78857.9 сая төгрөгөөр батлагдаж, эхний 9 сарын гүйцэтгэлээр 58353.8 сая төгрөг буюу 74.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Орлогын гүйцэтгэлийг тухайн тасалбар болгосон хугацааны төлөвлөгөөтэй харьцуулахад биелэлт 100.8 хувийн биелэлттэй байна.

Аймгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Хүснэгт №7 /сая төгрөгөөр/

| Орлогын нэр төрөл | Төлөвлөгөө жилээр | Төлөвлөгөө 9.30 | Гүйцэтгэл 9.30 | Гүйцэтгэлийн явц % | 9 сарын 30-ны гүйцэтгэл % |
|---|---|---|---|---|---|
| **Тусгай зориулалттай шилжүүлгээс санхүүжих** | 45706.5 | 33115.2 | 33065.2 | 72.3% | 99.8% |
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 25586.5 | 19008.9 | 20020.4 | 78.2% | 105.3% |
| **Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих** | 4374.2 | 3329.2 | 3180.0 | 72.6% | 95.5% |
| **Төсөвт байгууллагын үйл ажиллагаа, СХСангийн зээлийн эх үүсвэр, урьд** | 3190.7 | 2900.5 | 2593.6 | 81.2% | 89.4% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| оны үлдэгдлээс | | | | | |
| **Дүн** | **78857.9** | **58353.8** | **58859.2** | **74.6%** | **100.8%** |

Аймгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг бүтцээр харуулбал: График №2




ОН-ийн татварын болон татварын бус орлогын гүйцэтгэлийг татвар төлбөр хураамжийн нэр төрлөөр харуулбал дараах байдалтай байна.

- Аймагт төвлөрөх орлогын төлөвлөгөөний хэрэгжилт

Хүснэгт №8 /сая төгрөгөөр/

| д/д | Орлогын нэр төрөл | Батлагдсан төсөв | Гүйцэтгэл 9.30 | Биелэлт хувиар |
|---|---|---|---|---|
| 1 | **Аймгийн төсвийн орлого бүгд** | **8264.1** | **6306.2** | **76.3%** |
| 2 | **Аймгийн төсвийн татварын орлого** | **7908.9** | **5641.5** | **71.3%** |
| 2.1 | Газрын төлбөр | 135.0 | 85.7 | 63.5% |
| 2.2 | Үл хөдлөх хөрөнгийн албан татвар | 320.0 | 277.6 | 86.7% |
| 2.3 | Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 510.0 | 497.9 | 97.6% |
| 2.4 | Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр | 349.6 | 309.4 | 88.5% |
| 2.5 | Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвар | 6446.4 | 4290.2 | 66.5% |
| 2.6 | Улсын тэмдэгтийн хураамж | 148.0 | 180.7 | 122.1% |
| 3 | **Аймгийн төсвийн татварын бус орлого** | **355.1** | **664.7** | **187.2%** |
| 3.1 | Хүү, торгуулийн орлого | 340.1 | 664.7 | 195.4 |
| 3.2 | Бусад орлого | 0 | | |
| 3.3 | Орон нутгийн өмчийн оролцоотой Баянтээг ХК-ны ногдол ашиг | 15.0 | 0 | |

Аймагт төвлөрүүлэх орлого 9 дүгээр сарын 30-ны байдлаар 76.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөрийн орлогын гүйцэтгэл харьцангуй бага байна.

- Суманд төвлөрөх орлогын төлөвлөгөөний хэрэгжилт

Хүснэгт №9 /сая төгрөгөөр/

| д/д | Орлогын нэр төрөл | 2018 оны батлагдсан төсөв | Гүйцэтгэл 9.30 | Биелэлт хувиар |
|---|---|---|---|---|
| 1 | **Сумын татварын орлогын дүн** | **3199.5** | **2928.4** | **91.5%** |
| 1.1 | Үйл ажиллагааны орлого /Аж ахуй эрхэлсний орлого | 696.9 | 446.3 | 64% |
| 1.2 | Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүү | 881.8 | 902.9 | 102.4% |
| 1.3 | Хөрөнгө борлуулсны орлого | 85.0 | 96.3 | 113.3% |
| 1.4 | | | | |
| 1.5 | Улсын тэмдэгтийн хураамж | 138.7 | 97.4 | 70.2% |
| 1.6 | Бууны албан татвар | 60.6 | 12.1 | 19.9% |
| 1.7 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 36.8 | 38.0 | 103.3% |
| 1.8 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 521.1 | 360.7 | 69.2% |
| 1.9 | Ургамал ашигласны төлбөр | | | |
| 1.10 | Ойн нөөц ашигласны төлбөр | 152.5 | 147.6 | 96.8% |
| 1.11 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 259.3 | 356.0 | 137.3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.12 | Ус ашигласны төлбөр | 4.5 | 4.6 | 102.2% |
| 1.13 | Хүү торгууль | 353.8 | 466.5 | 131.8% |
| 1.14 | Нохойн татвар | 8.5 | 0 | |

Сумын орлогын гүйцэтгэл нийт дүнгээр 91.5 хувийн биелэлттэй байна. Үйл ажиллагааны орлого, бууны албан татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамж, нохойны татвар зэрэг орлогууд 70-аас доош хувийн гүйцэтгэлтэй байгаад анхаарч үзэх шаардлагатай байна.

Бууны албан татвар жилийн эцсээр орлого ороод ч тасрахаар байна. Томилолтоор ажилласан сумдад орлогын гүйцэтгэлийг гаргаж үзэхэд бүх сумдад бууны татварын орлогын гүйцэтгэл хамгийн бага биелэлттэй байсан.

Энэ нь буу эзэмшигч нас барсан болон, буугаа хүнд шилжүүлсэн тохиолдолд өөрчлөлтөө цагдаагийн байгууллагын бүртгэлээс хасуулдаггүй учраас 1 буу хэд хэдэн эзэмшигчтэй болсонтой холбоотой. Энэ талаар ИТХурал болон бусад сургалт семинараар яригддаг боловч дорвитой арга хэмжээ авахгүй байсаар байна.

- НД-ын санд төвлөрөх орлогын хэрэгжилт

Хүснэгт №10 /сая төгрөгөөр/

| № | Нийгмийн даатгалын сангийн төсөв | Орлого | | |
|---|---|---|---|---|
| | Сангийн төрөл | **2018 оны төсөв** | **Гүйцэтгэл 9.30** | **Биелэлт хувиар** |
| 1 | Тэтгэврийн даатгалын сан | 14889.7 | 11008.3 | 73.9% |
| 2 | Тэтгэмжийн даатгалын сан | 1606.1 | 1206.7 | 75.1% |
| 3 | ҮОМШӨ-ний даатгалын сан | 1165.9 | 830.7 | 71.2% |
| 4 | Ажилгүйдлийн даатгалын сан | 392.1 | 227.9 | 58.1% |
| | **Дүн** | **18053.8** | **13273.6** | **73.5%** |

НД-ын сангийн орлогын гүйцэтгэл 73.5 хувьтай байна.

- ЭМД-ын санд төвлөрөх орлогын хэрэгжилт

Хүснэгт №11 /сая төгрөгөөр/

| № | Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв | Орлого | | |
|---|---|---|---|---|
| | Орлогын эх үүсвэр | **Төлөвлөгөө** | **Гүйцэтгэл 09.30** | **Биелэлт хувиар** |
| 1 | Ажил олгогч, даатгуулагчаас төлөх | 3166.4 | 2973.9 | 94% |
| 2 | ХХЭрхлэгч иргэн, малчин суралцагсад | 671.6 | 565.6 | 84% |
| 3 | Бусад орлого | 0.5 | 0.5 | 100% |
| | | | | |
| | **Дүн** | **3838.5** | **3540.1** | **92.2%** |

**2.2 Төсөвт болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудад 9.0 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх боломж байна.**

Хархорин сумын спортын ордон 2017 онд шинээр ашиглалтад орсон. Тус ордон нь ашиглахгүй өрөөнүүд болон сул зай талбайгаа бизнес эрхлэгчдэд ТБОНӨ-ийн тухай хуулийн 28 дугаар зүйл болон Аймгийн ИТХ-аас баталсан журмын дагуу түрээсийн гэрээгээр эзэмшүүлсэн.

Тус ордонтой 8 хүн өрөө түрээслэх, 5 хүн талбай ашиглах, 8 байгууллага зал ашиглах гэрээ хийсэн байна. Эхний 6 сарын байдлаар залны хөлсөнд касст 1.6 сая төгрөгийг тушаасан байна. Эдгээрийн төлбөрийг тооцож үзэхэд жилдээ 17.3 сая төгрөгийн орлого орохоор байна. 2018 оны төсөвт тус байгууллага 8.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тусгажээ. Иймээс 2019 оны төсөвт өөрийн орлогыг 9.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

**2.3 2018 оны төсвийн жилд төсвийн тогтворжуулалтын сан болон ирээдүйн өв санд хуримтлуулах хөрөнгийн асуудал орон нутагт байхгүй болно.**

## БҮЛЭГ 3. 2018 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ, ХЭМНЭЛТТЭЙ, ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛЖ БАЙНА.

### 3.1 2018 оны төсвийг зардлын зүйл анги тус бүрээр хэмнэлттэй зарцуулж байна.

Аймгийн төсвийн нийт зарлагыг 2018 онд 78857.9 сая төгрөгөөр баталж, 9 сарын 30-ны гүйцэтгэлээр 52255.3 сая төгрөг зарцуулан 66.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Зарлагын гүйцэтгэлийг 9 сарын төлөвлөгөөтэй харьцуулахад 6833.8 сая төгрөгийн хэмнэлттэй буюу 88.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №12 /сая төгрөгөөр/

| | Төсвийн зарлага | 2018 оны төлөвлөлт | 9.30-ны төлөвлөлт | 9.30-ны гүйцэтгэл | Зөрүү | Гүйц-л жил | Гүйц-л 9.30 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 34538.6 | 25540.3 | 24659.1 | -881.2 | 71.4% | 96.5% |
| 2 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 4177.3 | 3095.2 | 3002.8 | -92.4 | 71.8% | 97.0% |
| 3 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 6689.8 | 4222.7 | 3898.8 | -323.9 | 58.3% | 92.3% |
| 4 | Хангамж, бараа материалын зардал | 1214.5 | 925.3 | 823.9 | -101.4 | 67.8% | 89.0% |
| 5 | Нормативт зардал | 3284.7 | 2188.0 | 1785.4 | -402.6 | 54.3% | 81.5% |
| 6 | Эд хогшил, урсгал засварын зардал | 505.1 | 467.6 | 409.8 | -57.8 | 81.1% | 87.6% |
| 7 | Томилолт, зочны зардал | 209.3 | 160.2 | 125.7 | -34.5 | 60.0% | 78.4% |
| 8 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1475.8 | 1250.2 | 1041.3 | -208.9 | 70.5% | 83.2% |
| 9 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2299.8 | 1829.2 | 1663.1 | -166.1 | 72.3% | 90.9% |
| 10 | Татаас | 260.7 | 189.1 | 158.6 | -30.5 | 60.8% | 83.8% |
| 11 | Урсгал шилжүүлэг | 13872.6 | 10128.5 | 8389.5 | -1739 | 60.4% | 82.8% |
| 12 | Хөрөнгийн зардал | 7196.4 | 6177.0 | 5020.0 | -1157 | 69.7% | 81.2% |
| 13 | Эргэн төлөгдөх зээл | 3133.3 | 2915.8 | 1277.3 | -1638.5 | 40.7% | 43.8% |
| | **Нийт зардлын дүн** | **78857.9** | **59089.1** | **52255.3** | **-6833.8** | **66.2%** | **88.4%** |

**Төвлөрсөн арга хэмжээний зарцуулалт:**

Халамжийн сангийн зардалд 10373.1 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 6296.3 сая төгрөг зарцуулжээ.

Өндөр насны тэтгэмжид 92.6 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 45.4 сая төгрөгийн тэтгэмжийг 1 хүнд олгосон байна.

Засаг даргын нөөц хөрөнгөнд 167.4 сая төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 138.1 сая төгрөгийг Аймгийн ЗДТГ-ын дансанд шилжүүлсэн.

Хамгаалах байрны ажилтны цалинд 10.0 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 5.8 сая төгрөг олгосон,

Онги-Ус суваг ОНӨҮГ-ын зардалд 5.0 сая төгрөг төлөвлөж 3.7 сая төгрөг зарцуулсан,

Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх үйл ажиллагааны зардалд 90.0 сая төгрөг төсөвлөснөөс 67.5 сая төгрөгийг олгосон,

Албан журмын даатгалд 46.6 сая төгрөгийг төлөвлөж 34.2 сая төгрөгийг зарцуулсан,

Зорилтот жилийн зардалд 200.0 сая төгрөг батлагдаж 135.0 сая төгрөгийг зарцуулжээ.

Хүснэгт №13 /сая төгрөгөөр/

| № | Нийгмийн даатгалын сангийн төсөв | Зарлага | | |
|---|---|---|---|---|
| | Сангийн төрөл | **2018 оны төсөв** | **Гүйцэтгэл 9.30** | **Биелэлт хувиар** |
| 1 | Тэтгэврийн даатгалын сан | 57659.0 | 39496.9 | 68.5% |
| 2 | Тэтгэмжийн даатгалын сан | 2030.7 | 2164.5 | 106.5% |
| 3 | ҮОМШӨ-ний даатгалын сан | 735.2 | 186.9 | 25.4% |
| 4 | Ажилгүйдлийн даатгалын сан | 534.4 | 261.6 | 48.9% |
| | **Дүн** | **60959.3** | **42109.9** | **69.0%** |

Хүснэгт №14 /сая төгрөгөөр/

| № | ЭМДаатгалын төсөв | Зарлага | | |
|---|---|---|---|---|
| | Зарцуулалтын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл 9.30 | Биелэлт хувиар |
| 1 | Төрийн өмчийн эмнэлэг | 4284.8 | 3281.5 | 76.5% |
| 2 | Хувийн эмнэлэг | 1157.8 | 507.4 | 43.8% |
| 3 | Рашаан сувилал | 2833.2 | 1923.3 | 67.8% |
| 4 | Эмийн сан | 926.2 | 670.2 | 72.3% |
| | **Дүн** | **9202.0** | **6382.4** | **69.3%** |

### 3.2 Төсвийг зарцуулахдаа Төсвийн болон ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлж байна.

2018 оны Төсвийн тухай хуулиар Өвөрхангай аймагт улсын төсвийн хөрөнгөөр 59 төсөл арга хэмжээ болон барилга байгууламжид 31771.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон 6 яамнаас 34 / багцалсан/ төсөл арга хэмжээний 29982.0 сая төгрөгийн эрхийг шилжүүлсэн байна. 2018 оны 9 дүгээр сарын байдлаар хөрөнгө оруулалтын 55 арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Худалдан авах ажиллагааны аргаар нь ангилбал нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 30, харьцуулалтын аргаар 7 тендер зарласан бөгөөд 5 тендер дахин зарлагдаж шууд гэрээ байгуулан нийт 57 гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, тендерийн зар, урилгыг цахим сайтаар зарлан мэдээлж, нийт худалдан авалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудын явц нь аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэдээллээр 90-100 хувийн гүйцэтгэлтэй 30, 60-85 хувийн гүйцэтгэлтэй 10, 55-30 хувийн гүйцэтгэлтэй 6,10-40 хувийн гүйцэтгэлтэй 5, ажил нь эхлээгүй гэрээ байгуулах шатанд 4 төсөл арга хэмжээ байна.

Барилга байгууламж угсралтын 8 ажлын санхүүжилт он дамжиж төсөвлөгдсөн тул энэ онд ашиглалтад орохооргүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг санхүүжүүлэхдээ 2018 оны 09 дүгээр сарын байдлаар гүйцэтгэгчид 5734.7 сая төгрөг, техник хяналтын зардал, магадалшгүй ажлын зардал, зураг төсвийн үнэнд 228.8 сая төгрөг нийт 5963.5 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Харин орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 4188.0 сая төгрөгийн 30 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 8, харьцуулалтын аргаар 3 тендер зарлаж, 7 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх эрхийг суманд болон байгууллагад шилжүүлж, 1 тендер дахин зарлагдаж шууд гэрээ байгуулан нийт 12 гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, тендерийн зар, урилгыг цахим сайтаар зарлан мэдээлж, нийт худалдан авалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.

Харин 2 ажлын худалдан авах ажиллагааг зарлаагүй байна. Төлөвлөгдсөн 30 төсөл арга хэмжээнээс 9 төсөл арга хэмжээ нь зураг төсвийн зардал болон үйл ажиллагааны зардал байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудын явц нь аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэдээллээр 95-100 хувийн гүйцэтгэлтэй 15, 35 хувийн гүйцэтгэлтэй 1, 60-75 хувийн гүйцэтгэлтэй 10, ажил нь эхлээгүй 3 төсөл арга хэмжээ байна.

Хужирт сумын инженерийн шугам сүлжээний зураг төсвийн зардалд батлагдсан 30.0 сая төгрөгийг Намнансүрэнгийн мэндэлсний 140 жилийн ой тэмдэглэх арга хэмжээний зардалд зарцуулахаар аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн байна. Одоогоор холбогдох шийдвэр гараагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг санхүүжүүлэхдээ 2018 оны 09 дүгээр сарын байдлаар гүйцэтгэгчид 3158.8 сая төгрөг, техник хяналтын зардалд 42.0 сая төгрөг, магадалшгүй ажлын зардалд 36.3 сая төгрөг, зураг төсвийн үнэнд 29.7 сая төгрөгийг нийт 32668.6 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Арвайхээр сумын 4-р сургуулийн гадна фасадын засварын ажил, Сант, Есөнзүйл сумдын багийн төвийн барилгын ажлууд дээр нэмэлт ажил гүйцэтгүүлэх 25.1 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлж, барилгын ажлыг ашиглалтад хүлээн авсан байна.

2018 оны улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудаас Нью констракшн ХХК-ийн гүйцэтгэж байгаа Гучин-Ус сумын 250 хүний суудалтай Соёлын төвийн барилгын ажил харьцангүй удаашралтай явагдаж байгаад аймгийн холбогдох байгууллагаас зохих хяналтыг тавьж тодорхой үүрэг өгч ажиллаж байна.

Аудитын явцад Бат-Өлзий, Хужирт, Хархорин, Баянгол,Төгрөг, Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Арвайхээр зэрэг сумдад ажиллаж, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа ажлын чанар байдлыг үзэж, ашиглагч байгууллагын удирдлага болон ажилтнуудтай ярилцаж, ажлын явцад тавьсан дотоод хяналтын баримт материалтай танилцахад, дараах ажлуудыг батлагдсан зураг, төсвийн дагуу гүйцэтгэж байна. Үүнд:

- ДШЛ ХХК-ийн 949.9 сая төгрөгөөр он дамжин гүйцэтгэж байгаа Бат-Өлзий сумын Соёлын төвийн барилгын ажил,
- Эс жи эм ХХК-ийн 46.9 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа Бат-Өлзий сумын ЕБС-ийн спорт залны барилгын засвар,
- ZMZ ХХК-ийн 727.3 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа Хужирт сумын төвийн бетон гүүрний ажил,
- Марал инж ХХК-ийн 82.4 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа Хужирт сумын Соёлын төвийн барилгын засвар,
- Дуутын нуруу ХХК-ийн 47.9 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа Хужирт сумын ЕБС-ийн спорт залны барилгын засвар,
- Навтгар хайрхан ХХК-ийн 148.2 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа Хархорин сумын Халдвартын эмнэлгийн барилгын засвар,
- Говийн нар констракшн ХХК-ийн 40.0 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа Хархорин сумын Эрдэнэ зуу музейн нийтийн бие засах газрын барилгын ажил,
- Харшийн гэгээ ХХК-ийн 1262.0 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа Хархорин сумын 400 хүний суудалтай Соёлын төвийн барилгын ажил,
- Химон констракшн ХХК-ийн 1027.6 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа Баянгол сумын Эрүүл мэндийн төвийн барилгын ажил,
- Тэд констракшн ХХК-ийн 2750.0 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа Богд сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын ажил,
- Эрч хүч хөгжил ХХК-ийн 657.9 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа Богд сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил,
- Жигүүр оргил ХХК-ийн 294.5 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа Нарийнтээл сумын Баянтээгийн эмнэлгийн барилгын өргөтгөлийн ажил,
- Навтгар хайрхан ХХК-ийн 689.1 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа аймгийн Спортын ордны бэлтгэлийн залны барилгын ажил,
- ӨВ МТХ ХХК-ийн 2000.0 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа аймгийн Хүний хөгжлийн төвийн барилгын ажил,
- Ган нэгдэл ХХК-ийн 814.4 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлууд байна.

Хөрөнгө оруулалтын барилга угсралт болон засварын ажлууд дээр аймгийн ГХБХБГазар, Барилгын хөгжлийн төв, Зураг төсвийн зохиогчоос газар дээр нь зохих хяналтуудыг тавьж заавар зөвлөгөө өгч ажлын дэвтэрт баримтжуулж ажилласан байна.

Мөн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг аймгийн Засаг даргын 2017 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн “Комиссын бүрэлдэхүүн томилох тухай” А/409 дүгээр захирамжийн дагуу мэргэжлийн байгууллагуудаас бүрдсэн ажлын хэсэг тогтмол хүлээн авч орхигдсон, чанаргүй гүйцэтгэсэн ажлуудыг тухай бүрд нь гүйцэтгүүлэн ажиллаж байна.

**3.3 Төсвийн хөрөнгөөр “Барих, шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн санхүүжилтийн асуудал тус аймагт байхгүй байна.**

**3.4 Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас, зээлийн асуудал тус аймагт байхгүй болно.**

## БҮЛЭГ 4.

ТЕЗ-ДЫН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨР НЬ ХҮРЭХ ҮР ДҮН ЗОРИЛТОТ ТҮВШИНД НИЙЦЭЖ, ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖ БАЙНА.

**4.1 ТЕЗ-дын хэрэгжүүлж буй хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлт зохистой байна.**

Монгол улсын Засгийн газрын гишүүн, төсвийн ерөнхийлөн захирагч нарын аймгийн Засаг даргатай 2018 онд байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасан хэрэгжүүлэх үйл ажиллагааг тоогоор дурдвал:

- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын Өвөрхангай аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 онд хамтран ажиллах гэрээнд 13 үйл ажиллагааг,
- Шадар сайдын Өвөрхангай аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 онд хамтран ажиллах гэрээнд 22 үйл ажиллагааг,
- Сангийн сайдын Өвөрхангай аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 онд хамтран ажиллах гэрээнд 27 үйл ажиллагааг,
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын Өвөрхангай аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 онд хамтран ажиллах гэрээнд эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын орон нутаг дахь нэгж, албадын үйл ажиллагааг бэхжүүлэх 9 чиглэлээр 49 үйл ажиллагааг,
- Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын сайдын Өвөрхангай аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 онд хамтран ажиллах гэрээнд 13 чиглэлээр 118 үйл ажиллагааг,
- Эрүүл мэндийн сайдын Өвөрхангай аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 онд хамтран ажиллах гэрээнд 8 чиглэлээр 47 үйл ажиллагааг,
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын Өвөрхангай аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 онд хамтран ажиллах гэрээнд 13 үйл ажиллагааг,
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын Өвөрхангай аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 онд хамтран ажиллах гэрээнд 9 чиглэлээр 42 үйл ажиллагааг,
- Зам тээврийн хөгжлийн сайдын Өвөрхангай аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 онд хамтран ажиллах гэрээнд 4 чиглэлээр 24 үйл ажиллагааг,
- Эрчим хүчний сайдын Өвөрхангай аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 онд хамтран ажиллах гэрээнд 13 үйл ажиллагааг,
- Барилга, хот байгуулалтын сайдын Өвөрхангай аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 онд хамтран ажиллах гэрээнд 6 чиглэлээр 49 үйл ажиллагааг,
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын Өвөрхангай аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 онд хамтран ажиллах гэрээнд 8 чиглэлээр 58 үйл ажиллагааг,
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын Өвөрхангай аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 онд хамтран ажиллах гэрээнд 14 үйл ажиллагааг,
- Батлан хамгаалахын сайдын Өвөрхангай аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 онд хамтран ажиллах гэрээнд 5 чиглэлээр 27 үйл ажиллагааг тус тус тусган хэрэгжүүлж байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч-Өвөрхангай-2020” мөрийн хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор баталсан байна.

Хөтөлбөр боловсруулсантай холбоотой аймгийн Засаг дарга, ЗДТГазраас дэд хөтөлбөрүүдийг боловсруулан аймгийн ИТХ-ын тогтоолуудаар баталсан бөгөөд 2018 онд дараах хөтөлбөрүүд хэрэгжиж байна.Үүнд:

- “Арвайхээр хотын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр” аймгийн ИТХ-ын 2013 оны 04 дүгээр сарын 11-ны 33 дугаар тогтоол

- “Иргэний боловсрол хөтөлбөр” аймгийн ИТХ-ын 2014 оны 04 дүгээр сарын 14-ний 20 дугаар тогтоол
- “Аймгийн Хөгжимт драмын театрын хөгжлийн хөтөлбөр” аймгийн ИТХ-ын 2014 оны 09 дүгээр сарын 19-ний 70 дугаар тогтоол
- “Стандарттай-Өвөрхангай хөтөлбөр” аймгийн ИТХ-ын 2015 оны 06 дугаар сарын 10-ны 38 дугаар тогтоол
- “Шатар аймгийн хөтөлбөр” аймгийн ИТХ-ын 2017 оны 04 дүгээр сарын 20-ны 30 дугаар тогтоол
- “Адил боломж хөтөлбөр” аймгийн ИТХ-ын 2017 оны 04 дүгээр сарын 28-ны 39 дүгээр тогтоол
- “Соёлын үйлдвэрлэл хөтөлбөр” аймгийн ИТХ-ын 2017 оны 04 дүгээр сарын 28-ны 40 дүгээр тогтоол
- “Хоршоог хөгжүүлэх хөтөлбөр” аймгийн ИТХ-ын 2017 ны 06 дугаар 09-ний 54 дүгээр тогтоол
- “Олон нийтийн оролцоот сургууль” хөтөлбөр аймгийн ИТХ-ын 2017 оны 07 дугаар сарын 03-ны 55 дугаар тогтоол
- “Хүүхдэд ээлтэй аймаг хөтөлбөр” аймгийн ИТХ-ын 2017 оны 07 дугаар сарын 03-ны 56 дугаар тогтоол
- “Аймгийн мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах хөтөлбөр” аймгийн ИТХ-ын 2017 оны 08 дугаар сарын 31-ний 70 дугаар тогтоол
- “Өвөрхангай аймгийн эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх хөтөлбөр” аймгийн ИТХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 28-ны 98 дугаар тогтоол
- “Аюулгүй иргэн- Амар тайван Өвөрхангай хөтөлбөр” аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 22-ны 101 дүгээр тогтоол
- “Архидалтгүй –Өвөрхангай хөтөлбөр” аймгийн ИТХ-ын 2018 оны 03 дугаар сарын 23-ны 16 дугаар тогтоол
- “Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын хөтөлбөр” аймгийн ИТХ-ын 2018 оны 04 дүгээр сарын 27-ны 33 дугаар тогтоол

Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан дараах хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Үүнд:

- “Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” аймгийн Засаг даргын 2012 оны 03 дугаар сарын 27-ны а/113 дугаар захирамж
- “Залуу малчдыг дэмжих хөтөлбөр” аймгийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 24-ний а/540 дугаар захирамж
- “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр” аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 28-ны а/199 дүгээр захирамж
- “Төрийн албан хаагчийн сургалт-хөгжил аймгийн хөтөлбөр” аймгийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 09-ний а/525 дугаар захирамж

Салбараар нь авч үзвэл хууль зүйн салбарын 5, боловсрол, соёлын салбарын 7, эдийн засгийн 1, эрүүл мэндийн салбарын 1, хөдөө аж ахуйн салбарын 3, байгаль орчны салбарын 2 хөтөлбөр тус тус хэрэгжиж байна.

Өвөрхангай аймгийн нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 06/02 дугаар тогтоолоор баталжээ. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч-Өвөрхангай-2020” мөрийн хөтөлбөрийн 4 бүлгийн 73 зорилтын 268 арга хэмжээнээс нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд:

- 1 дүгээр бүлгийн байгаль орчин, газрын харилцааны 4 зорилтын 24 арга хэмжээнээс 2 арга хэмжээг, аялал жуулчлалын 1 зорилтын 9 арга хэмжээнээс 2 арга хэмжээг,
- 2 дугаар бүлгийн эдийн засаг, төсөв санхүүгийн 9 зорилтын 37 арга хэмжээнээс 11 арга хэмжээг, аж үйлдвэр, бизнесийн таатай орчин, худалдаа үйлчилгээний 3 зорилтын 21 арга хэмжээнээс 12 арга хэмжээг, хөдөө аж ахуйн

салбарын 5 зорилтын 21 арга хэмжээнээс 8 арга хэмжээг, хот байгуулалт, дэд бүтэц, тээвэр ложистикийн 2 зорилтын 19 арга хэмжээнээс 19 арга хэмжээг,

- 3 дугаар бүлгийн эрүүл мэндийн 9 зорилтын 38 арга хэмжээнээс 11 арга хэмжээг, боловсролын 8 зорилтын 30 арга хэмжээнээс 10 арга хэмжээг, соёл, урлаг, спортын 5 зорилтын 36 арга хэмжээнээс 12 арга хэмжээг, хөдөлмөр эрхлэлтийн 3 зорилтын 11 арга хэмжээнээс 3 арга хэмжээг, хүүхэд залуучууд, гэр бүлийн 2 зорилтын 7 арга хэмжээнээс 3 арга хэмжээг, нийгмийн хамгааллын 3 зорилтын 11 арга хэмжээнээс 6 арга хэмжээг,
- 4 дүгээр бүлгийн төрийн үйлчилгээний 13 зорилтын 32 арга хэмжээнээс 10 арга хэмжээг, хууль эрх зүйн 4 зорилтын 16 арга хэмжээнээс 3 арга хэмжээг, онцгой байдлын 2 зорилтын 5 арга хэмжээнээс 2 арга хэмжээг тус тус тусган хэрэгжүүлж байна.

Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 06/08 дугаар тогтоолоор аймгийн 2018 оны төсөв батлахдаа Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлтийг 1-р хавсралтаар баталсан байна. Үр дүнгийн үзүүлэлтүүдийг зөвхөн аймгийн ИТХ болон аймгийн ЗДТГ, Засаг даргын дэргэдэх 5 газар, албатуудын үйл ажиллагааны хүрэх үр дүнг оруулж баталсан байна.


Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлт





Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлтийн судалгааг дээрх аймгийн ИХТ-аар батлагдсан үр дүнгийн үзүүлэлтүүдээр гаргав.

**4.2 ТЕЗ-д 2018 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж, төсвийг зориулалтын дагуу зарцуулж байна.**

Монгол улсын Засгийн газрын гишүүн, төсвийн ерөнхийлөн захирагч нарын аймгийн Засаг даргатай 2018 онд байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасны дагуу биелэлтийг эхний хагас жилийн байдлаар гаргаж дараах яамнуудад тайлагнасан байна. Үүнд: Хууль зүй дотоод хэргийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Батлан хамгаалах яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрчим хүчний яам.

Зарим яамдад хүргүүлсэн хамтран ажиллах гэрээний биелэлтээс 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний тоон болон чанарын үзүүлэлтийн биелэлтийг авч үзвэл:

| Шалгуур үзүүлэлтүүд | 2018 онд хүрэх түвшин | 2018 оны эхний хагас жилд хүрсэн түвшин |
|---|---|---|
| **БОЛОВСРОЛ** | | |
| ***СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ:*** . | | |
| Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь | 88.3 | 83.3 |
| Цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн эзлэх хувь | 60.2 | 60.2 |
| 5 настай хүүхдийн СӨБ-д хамрагдалт | 98.0 | 93.0 |
| Цэцэрлэгийн мэргэжлийн багшийн хангалтын хувь | 100.0 | 98.0 |
| Хөгжмийн багштай цэцэрлэгийн эзлэх хувь | 60.9 | 58.9 |
| Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь | 50.1 | 60.0 |
| ***ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ:*** . | | |
| ЕБС-ийн мэргэжлийн багшийн хангалтын хувь | 100 | 100 |
| Бага боловсролын хамран сургалтын хувь /цэвэр/ | 94.7 | 94.8 |
| Суурь боловсролын хамран сургалтын хувь /цэвэр/ | 92.4 | 91.6 |
| 6 настай хүүхдийн сургуульд хамрагдалтын хувь | 90.2 | 90.2 |
| Дотуур байранд хүсэлт гаргасан хүүхдийн хамрагдалтын хувь | 90.1 | 100 |
| ***ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ:*** | | |
| Ерөнхий боловсролын сургууль цэцэрлэг , насан туршийн боловсролыг төв болон бусад байгууллага, иргэдээс зохион байгуулж буй дугуйлан, секц, клубт хамрагдсан хүүхдийн тоо | Нийт суралцагчдын 80-аас доошгүй хувь | Цэцэрлэг , ЕБС-ийн 22569 хүүхэд /давхардсан тоогоор/хөгжүүлэх сургалтад хамрагдаж, нийт цэцэрлэг, ЕБС-ийн сурагчдын 75 хувийг эзэлж байна. |
| Шинээр байгуулсан дугуйлан, секц, клубийн тоо | Нийт дугуйлан, секцийн 5-аас доошгүй хувь | Нийт дугуйлан, секцийн 7 хувь шинээр байгуулагдсан дугуйлан, секц, клубууд эзэлж байна. |
| Дугуйлан, секц, клубийг удирдсан хүүхдийн тоо | Дугу йлан удирдсан нийт багшийн 10-аас доошгүй хувь | 200 сурагч байна. Нийт дугуйлан, секц, клуб хичээллүүлсэн хүний 35 хувийг эзэлж байна |
| Дугуйлан, секц, клубийг удирдсан сайн дурын иргэдийн тоо | Дугу йлан удирдсан нийт багшийн 20-аас доошгүй хувь | Сайн дурын иргэд СӨББ-д илүүтэй ажилласан ба нийт багш нарын 21 хувийг эзэлж байна. |
| Хүүхдийн авьяасыг хөгжүүлэх зорилгоор цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд орон нутгийн төсвийн хөрөнгө, иргэд, байгууллагын хандив, тусламжаар нийлүүлсэн сургалтын хэрэглэгдэхүүний зардлын хэмжээ | Орон нутгаас зарцуулах төсвийн 20-оос доошгүй хувь | Цэцэрлэг , ЕБС-д хүүхэд хөгжүүлэхэд төсөл хөтөлбөрөөс149.7 сая, олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар 165.0 сая төгрөг зарцуулсан байна. |
| ***НОМЫН САНГИЙН ФОНДЫН БАЯЖИЛТ ХИЙХ:*** | | |
| ЕБС, насан туршийн боловсролын төвийн болон орон нутаг | 1700 | Давхардс |

| | | | |
|---|---|---|---|
| | дахь номын сангаар үйлчлүүлсэн хүүхдийн тоо | 0 | ан тоогоор 19150 |
| | ЕБС, насан туршийн боловсролын төвийн болон бусад газар байгуулагдсан номын клуб, тэдгээрт хамрагдсан хүүхдийн тоо | Дунд ахлах ангийн нийт суралцагчдын 50-аас доошгүй хувь | ДЗОУБ-тай хамтран “1 сургууль 10 клуб” аяныг хэрэгжүүлэн, ЕБС-ийн номын сангийн дэргэд нийт 8 клуб ажиллаж түүнд дунд, ахлах ангийн суралцагчдын 60 хувь хамрагдсан. |
| | ЕБС-ийн хүүхдэд номыг бүтээлчээр уншуулах арга зүй эзэмшүүлэх сургалтад хамрагдан багшийн тоо | Нийт багшийн 40-өөс доошгүй хувь | Нийт багшийн 38 орчим хувь нь хамрагдсан. |
| | Үндэсний хэмжээнд хүүхдийн хэл, сэтгэхүй, унших чадварыг хөгжүүлэх аян, уралдаанд оролцсон хүүхэд, иргэний тоо | Бага ангийн хүүхэдтэй нийт эцэг эхийн 50-аас доошгүй хувь | Бага ангийн хүүхэдтэй нийт эцэг эхийн 66 хувь нь сурагчдын бичиг үсэг сурах болон судалгааны ажилд идэвхтэй оролцон хамтран ажилласан. |
| | ***БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР*** | | |
| | Биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагчдын тоо | 5696<br>6 | 14551 |
| | Спортоор хичээллэгчдийн тоо | 7825 | 1078 |
| | Биеийн тамираар тогтмол хичээллэгчдийн тоо | 4970<br>2 | 5424 |
| | Бие бялдрын хөгжил чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдагчдын тоо | 5185 | 2479 |
| | Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдагчдаас А,В үнэлгээтэй иргэдийн тоо | 2174 | 1405 |
| | **ЭРҮҮЛ МЭНД** | | |
| | Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь | 81.1 %-аас дээш | 36.9% |
| | Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлэгд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь | 81.9 %-аас дээш | 37% |
| | Хөхний өмөнгийн эрт илрүүлэгд хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь | 2965 9-аас дээш | 10143 |
| | Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэгд хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь | 74.1 %-аас дээш | 25.4% |
| | Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь | 31.1 %-аас дээш | 28.6% |
| | Өрхийн, сумын эрүүл мэндийн төвийн нийт үзлэгт гэрийн эргэлтийн хувь | 24.4 %-аас дээш | 11.9 |
| | В вируст хепатитийн эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь | 98.6-аас доошгүй | 98.4 |
| | Тавт сэргийлэх тарилгын хамралтын хувь | 99.8-аас доошгүй | 94.9 |
| | Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг сэргийлэх тарилгын хамралтын хувь | 99.9-аас доошгүй | 94.6 |
| 0 | Эхийн эндэгдлийн түвшин(1000 амьд төрөлт тутамд) | 0 | 0 |
| 1 | Нялхсын эндэгдлийн түвшин(1000 амьд төрөлт тутамд) | 15.6 %-аас доош | 23.2 |
| 2 | Нярайн эндэгдлийн түвшин(1000 амьд төрөлт тутамд) | 9.0% -аас доош | 14.8 |
| 3 | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин(1000 амьд төрөлт тутамд) | 19.5 %-аас доош | 26.4 |
| 4 | Амьгүй төрөлтийн түвшин(1000 амьд төрөлт тутамд) | 3.6% -аас доош | 6.3 |
| 5 | Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь | 91.7 %-аас дээш | 88.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин | 40.6 %-аас доош | 2.5 |
| 7 | Сүрьеэгийн өвчлөлийн түвшин (10000 хүн амд) | 5.4% -аас доош | 1.9 |
| 8 | Сүрьеэгийн эмчилгээний амжилтын хувь | 88.0 %-аас дээш | 96.0 |
| 9 | Эрүүл мэндийн даатгалын хамралтын хувь | 93.5 %-аас дээш | 99.7 |

Хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрүүдээс боловсролын салбарын буюу Шатар, Адил боломж, Соёлын үйлдвэрлэл, Олон нийтийн оролцоот сургууль, Хүүхдэд ээлтэй аймаг зэрэг хөтөлбөрүүд “үр дүнтэй” буюу зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүнтэй гэж хяналт шинжилгээ үнэлгээгээр үнэлэгдсэн байна.

Харин “Стандарттай-Өвөрхангай”, “Арвайхээр хотын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр”, “Аймгийн мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах хөтөлбөр”-ийн хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна. Хангалтгүй байгаа шалтгаан нь тухайн байгууллагын удирдлага зохион байгуулалт болон төсөв, хөрөнгө дутмаг байгаатай холбоотой байна.

Аймгийн хөтөлбөрийн хэрэгжилт 2018 оны эхний хагас жилийн байдлаар:

| | Хөтөлбөрийн нэр | Хэрэгжих Хугацаа | Биелэлт % | Хагас жилд зарцуулсан хөрөнгө |
|---|---|---|---|---|
| | “Арвайхээр хотын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр” | 2013-2018 | 26.6% | - |
| | “Иргэний боловсрол” хөтөлбөр | 2014-2018 | 90.0% | 10.0 сая |
| | Аймгийн Хөгжимт драмын театрын хөгжлийн хөтөлбөр | 2015-2020 | 57.1% | - |
| | “Стандарттай-Өвөрхангай” хөтөлбөр | 2015-2020 | 58.0% | - |
| | “Шатар” аймгийн хөтөлбөр | 2017-2020 | 90.0% | - |
| | “Адил боломж” хөтөлбөр | 2017-2021 | 90.0% | - |
| | “Соёлын үйлдвэрлэл” хөтөлбөр | 2017-2020 | 90.0% | - |
| | “Хоршоог хөгжүүлэх” хөтөлбөр | 2017-2020 | 63.3% | - |
| | “Олон нийтийн оролцоот сургууль” хөтөлбөр | 2017-2020 | 90.0% | 707.9 сая |
| | “Хүүхдэд ээлтэй аймаг” хөтөлбөр | 2017-2020 | 92.5% | 1.624.3 сая |
| | Аймгийн мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах хөтөлбөр | 2016-2020 | 28.5% | - |
| | Өвөрхангай аймгийн эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх хөтөлбөр | 2017-2024 | 52.8% | |
| | Аюулгүй иргэн- Амар тайван Өвөрхангай | 2017-2020 | 76.0% | 30 .2 сая |
| | “Архидалтгүй-Өвөрхангай” хөтөлбөр | 2018-2020 | 70.0% | |
| | Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын хөтөлбөр | 2018-2022 | - | Хугацаа болоогүй |
| | **Ерөнхий үнэлгээ** | | **69.6%** | |

Хэдийгээр дэд хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж байгаа боловч хөтөлбөрүүдийг анх батлахдаа санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой тусгаагүй, улс, орон нутгийн төсөв, хөгжлийн сан, төсөл хөтөлбөр, хандив тусламжаар гэж оруулснаас хөтөлбөр тус бүр дээр төсөв санхүүгийн гүйцэтгэл гаргах боломжгүй байна.

Мөн дэд хөтөлбөрүүдтэй адил аймгийн нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд шаардлагатай хөрөнгийн хэмжээг мөнгөн дүнгээр илэрхийлээгүй, эх үүсвэр хэсэгт зөвхөн орон нутгийн төсвөөр, улсын төсвөөр гэх мэтээр заасан байна.

Аймгийн нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу жилийн эцэст аймгийн ИТХ-д танилцуулж ЗГХЭГ-т тайлагнах тул одоогоор биелэлт гаргаагүй байна.

**4.3 Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалттай ажиллаж байна.**

Аймгийн Засаг даргын Тамгын газраас сум, агентлагуудын жилийн эцсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамжид аймгийн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг нэг шалгуур үзүүлэлт болгон оруулж өгснөөр бүх байгууллага, албан хаагчид салбартай холбоотой аймгийн хөтөлбөрүүдийг хяналтад авч, хувийн хэрэг нээн баяжилт хийж, ажлын байрны тодорхойлолт болон үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлж, тайлагнаж хэвшсэн байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс явцын хяналт-шинжилгээг аймгийн ЗДТГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Баянгол, Төгрөг, Зүүнбаян-Улаан, Өлзийт, Хархорин, Есөнзүйл сумдын Засаг даргын Тамгын газар бусад төсөвт байгууллагууд, аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газар, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Шүүхийн шинжилгээний алба зэрэг нийт 33 байгууллагын 2018 оны үйл ажиллагаанд хийж, арга зүйн зөвлөмж өгч ажилласан байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны 255 дугаар тушаалын дагуу Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Есөнзүйл, Нарийнтээл, Хайрхандулаан, Уянга, Тарагт сумдын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагууд, Арвайхээр суманд байрлах төрийн болон төрийн өмчит 87 байгууллагын 3077 албан хаагчийг хамруулан хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн албаны сахилга хариуцлага, дэг журам, ажлын байрны аюулгүй байдал, гарч болзошгүй аливаа эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар удирдамжийн дагуу нэгдсэн шалгалтыг зохион байгуулж, ЗГХЭГ-т хугацаанд нь тайлагнажээ.

Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газраас сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын хамруулан зөвлөн туслах чиглэлээр сургалт-семинар зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүд болон орон нутагт сумдын Засаг даргын орлогч, төрийн захиргааны ажилтан нар аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудлыг хариуцан нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавин хэрэгжилтийг тооцож ажилласнаар төсөвт байгууллага хоорондын уялдаа холбоо сайжирч хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ахиц гарсан байна.

Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон дүрэм, журам, норм, стандартын биелэлтийг 31 төсвийн байгууллагыг хамруулан аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт, дотоод аудитын ажил хийж гүйцэтгэсэн байна.

**ДҮГНЭЛТ**

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2018 ОНЫ ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТТАЙ, ТЕЗ-ДЫН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨР НЬ ХҮРЭХ ҮР ДҮН ЗОРИЛТОТ ТҮВШИНД НИЙЦЭЖ, ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖ БАЙНА.

- 2018 оны төсвийн орлого зарлагыг бодитой төлөвлөсөн байна.
- 2018 оны төсвийн орлогын төлөвлөгөө бүрэн хэрэгжих боломжтой байна.

- 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, хэмнэлттэй, үр дүнтэй зарцуулж байна.
- ТЕЗ-дын хэрэгжүүлж буй хөтөлбөр нь хүрэх үр дүн зорилтот түвшинд нийцэж, төсвийг зориулалтын дагуу зарцуулж байна.

## ЗӨВЛӨМЖ

Аудитын тайлан, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

**Аймгийн ИТХ-ын дарга А.Ишдорж, СТСХэлтсийн дарга Д.Нэмэхбаяр нарт:**

1. Аймагт төвлөрүүлэх татварын орлогыг татварын бааз суурь нэмэгдэж байгаатай уялдуулан нөөц бололцоог бүрэн судалж бодитоор төлөвлөх.

2. Буу эзэмшигчдийн бүртгэл судалгааг холбогдох байгууллагуудтай хамтарч үнэн зөвөөр бүртгэж, бууны албан татварын төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР : Л.ЛАМААЧИН

АУДИТЫН МЕНЕЖЕР: Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР: Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Д.НАРАНТУЯА

2018 ОНЫ 10 ДУГААР САРЫН 31

САГ-2018/02-СА 2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц

## ЗӨВЛӨМЖ

Аудитын тайлан, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

**Аймгийн ИТХ-ын дарга А.Ишдорж, СТСХэлтсийн дарга Д.Нэмэхбаяр нарт:**

1. Аймагт төвлөрүүлэх татварын орлогыг татварын бааз суурь нэмэгдэж байгаатай уялдуулан нөөц боломжоог бүрэн судалж бодитоор төлөвлөх.

2. Буу эзэмшигчдийн бүртгэл судалгааг холбогдох байгууллагуудтай хамтарч үнэн зөвөөр бүртгэж, бууны албан татварын төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Л.ЛАМААЧИН

АУДИТЫН МЕНЕЖЕР: Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР: Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Д.НАРАНТУЯА

2018 ОНЫ 10 ДУГААР САРЫН 30

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас:7032 2073

2018.11.01 № 2б/541

танай 2018.10.31 -ны № 194 -т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Дараах залруулгыг хийх шаардлагатай байна.

Бүлэг 1.1-т бичигдсэн орон нутгийн сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн улс төрийн албан тушаалтны тэтгэмжийн 342.5 сая төгрөгийг 2017 онд улсын төсвөөс шийдвэрлэсэн тул хасах.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.НЭМЭХБАЯР

012301016

D:My Doc. A5 alban bichig /ZDTG/

## Холбогдох байгууллагын санал өгөх тайлбар

Өвөрхангай аймгийн СТСХэлтсийн даргын аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн санал өгөх тайлбар

1. Бүлэг-1.1-д. залруулгыг хийх гэсэнд “МУ-ын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай хуулиуд болон ЗГ-ын тогтоол, байгууллагын дотоод журмыг тус тус үндэслэн 2018 онд тэтгэвэрт гарах нас болсон төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын тэтгэмжийн зардлыг 177.6 сая төгрөг, Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн шийдвэрээр 1м3 халаалтын үнэ 10 хувиар нэмэгдсэн, 2017 оны 10 дугаар сараас ахмадын өргөө ашиглалтад орохтой холбоотой урсгал зардлыг 64.8 сая төгрөг, сүүлийн жилүүдэд малын гоц халдварт өвчний дэгдэлт ихсэж байгаатай холбоотой мал эмнэлгийн үйлчилгээний зардал 409.0 сая төгрөг зэргээр нэмэгдүүлж, холбогдох судалгаа шинжилгээ, баримт материалыг тайлбарын хамт хүргүүлжээ.” гэж залруулж өгсөн.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 11 сарын 01 өдөр    Дугаар А/17    Арвайхээр

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 19 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх”-ийн 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, мөн 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.40 дэх заалт, 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-д хийсэн аудитын тайлан /САГ-2018/02-СА/-г батлсугай.

2. Аудитын тайланг ҮАГ-ын Санхүүгийн аудитын газар, аймгийн ИТХурал, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 12 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн ИТХурлын дарга /А.Ишдорж/, аймгийн Засаг дарга /Г.Ганболд/ нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитын менежер /Д.Гансүх/-т даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Л.ЛАМААЧИН

№ 450104

D:\Auditiin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032-3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2018.11.02. № 201.

танай_____________-ны №_____________-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН САГ-т

Төсвийн байнгын хорооны 2017 оны "Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай" 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын А/06 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад хийсэн аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт 36 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Л.ЛАМААЧИН

450399

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A5 toot

ОНТГ-Хавсралт №1

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН СУДАЛГАА

Аймгийн нэр: Өвөрхангай

| № | Үзүүлэлт | Сангийн яамны хянасан дүн | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Анх батлагдсан | Тодотгол-1 | Тодотгол-2 |
| А | Б | 1 | 2 | 3 | 4 |
| | **ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар** | | 2017-12.01-ны 06/08 | | |
| | **ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО** | **9,821.2** | | | |
| | **НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **74,025.5** | **78,857.9** | - | - |
| | **УРСГАЛ ОРЛОГО** | **9,821.1** | **8,722.1** | - | - |
| | Татварын орлого | 9,292.2 | 7,908.9 | | |
| | Татварын бус орлого | 528.9 | 813.2 | | |
| | **ХӨРӨНГИЙН ОРЛОГО** | | **881.8** | | |
| | **ТУСЛАМЖИЙН ОРЛОГО** | **64,204.4** | **68,419.7** | | |
| | **БУСАД ЭХ ҮҮСВЭР** | | | | |
| | **БАЙГУУЛЛАГЫН ӨӨРИЙН ОРЛОГО** | | **834.3** | | |
| | **ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | | | | |
| | **ӨМНӨХ ОНЫ ҮНДСЭН ТЭНЦЛИЙН АШИГ (ӨМНӨХ ОНЫ ДАВСАН ОРЛОГООС, ХЭМНЭГДСЭН ЗАРДЛААС, МӨНГӨН ХӨРӨНГИЙН ҮЛДЭГДЛЭЭС)** | | | | |
| | **ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГА** | **23,944.9** | | | |
| | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **74,025.5** | **78,857.9** | - | - |
| | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **74,025.5** | **73,170.2** | - | - |
| | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 55,470.6 | 54,615.3 | | |
| | ХҮҮ | | | | |
| | ТАТААС | 57.0 | 57.0 | | |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 18,497.9 | 18,497.9 | | |
| | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **3,208.4** | | |
| | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | | **2,479.3** | | |
| | **УРСГАЛ ТЭНЦЭЛ** | **(64,204.4)** | **(64,448.1)** | - | - |
| | **НИЙТ ТЭНЦЭЛ** | - | **(0.0)** | - | - |
| | **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | | | |
| | **1.Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт** | | | | |
| | **2.Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих** | | | | |
| | **3.Бусад** | | | | |

Судалгаа гаргасан: ТАБ-ын ажилтны нэр, албан тушаал

Хянасан: Тэргүүлэх аудитор

Аудитын менежер

ОНТГ-Хавсралт №3

## Орон нутгийн төсвийн орлогын судалгаа

Аймгийн нэр: Өвөрхангай

/сая.төг/

| № | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | 2018 он | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2018 төл-өө | 2018 оны төл-гөө 9.30 | Гүйцэтгэл 9.30 | Зөрүү |
| А | Б | 1 | | 3 | 4 | 5=4-3 |
| | **НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **74,595.8** | **78,857.9** | **58,353.8** | **58,859.2** | **505.4** |
| | **НИЙТ ОРЛОГО** | **11,348.0** | **11,462.8** | 7,195.7 | 8,204.2 | **1,008.5** |
| **А** | **УРСГАЛ ОРЛОГО** | **11,348.0** | **11,377.8** | **7,195.7** | 8,204.2 | **1,008.5** |
| 1 | **Татварын орлого** | **10,120.8** | **10,564.6** | 6,560.0 | 7,086.8 | **526.8** |
| 1.1 | **Орлогын албан татвар** | **6,858.5** | **5,506.3** | 3,607.4 | 3,458.9 | **(148.5)** |
| 1.1.1 | Хувь хүний орлогын албан татвар | 7,800.7 | 6,446.3 | 4,547.4 | 4,290.2 | (257.2) |
| 1.1.2 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (942.2) | (940.0) | (940.0) | (831.3) | 108.7 |
| 1.2 | **Өмчийн татвар** | | | - | | - |
| 1.3 | **Дотоодын бараа, үйлчилгээний албан татвар** | **512.8** | **510.0** | **460.6** | **498.0** | **37.4** |
| 1.3.1 | Тусгай зориулалтын орлого | | | | | - |
| 1.3.2 | Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 512.8 | 510.0 | 460.6 | 498.0 | 37.4 |
| 1.4 | **Бусад татвар /төлбөр хураамж/** | **2,749.5** | **4,548.3** | **2,492.0** | **3,129.9** | **637.9** |
| 2 | **Татварын бус орлого** | **1,227.2** | **813.2** | **635.7** | 1,117.4 | **481.7** |
| **Б** | **ХӨРӨНГИЙН ОРЛОГО** | | **85.0** | | | - |
| Б-1 | Хөрөнгө борлуулсны орлого | | 85.0 | | | - |
| **В** | **ТУСЛАМЖИЙН ОРЛОГО** | **63,247.8** | **67,395.1** | **51,158.1** | **50,655.0** | **(503.1)** |
| В-1 | ОН-ийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 2,253.9 | 4,374.2 | 3,329.2 | 3,183.0 | (146.2) |
| В-2 | Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг | 12,415.7 | 14,123.7 | 11,813.2 | 11,813.2 | - |
| В-3 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 45,239.9 | 45,706.5 | 33,115.2 | 33,065.2 | (50.0) |
| В-4 | байгууллагын өөрийн орлого | - | | | | - |
| В-5 | Бусад тусламж | 3,338.3 | 3,190.7 | 2,900.5 | 2,593.6 | (306.9) |
| Г | **БУСАД ЭХ ҮҮСВЭР** | | - | | | |
| Г-1 | **БАЙГУУЛЛАГЫН ӨӨРИЙН ОРЛОГО** | | | | | |
| Г-2 | **ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | | | | | |
| Г-3 | **ӨМНӨХ ОНЫ ҮНДСЭН ТЭНЦЛИЙН АШИГ (ӨМНӨХ ОНЫ ДАВСАН ОРЛОГООС, ХЭМНЭГДСЭН ЗАРДЛААС, МӨНГӨН ХӨРӨНГИЙН ҮЛДЭГДЛЭЭС)** | | | | | |

Нэгтгэж гаргасан: ТАБ-ын ажилтны нэр, албан тушаал

Хянасан: Тэргүүлэх аудитор

Аудитын менежер

ОНТГ-Хавсралт №4

**Орон нутгийн төсвийн зарлагын судалгаа**

Аймгийн нэр: Өвөрхангай

/сая.төг/

| № | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | 2018 он | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2018 төл-өө | 2018 оны төл-гөө 9.30 | Гүйцэтгэл 9.30 | Зөрүү |
| А | Б | 1 | 2 | 4 | 5 | 5=4-3 |
| | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР** | **74,474.8** | **78,857.9** | **59,089.1** | **52,255.3** | **(6,833.8)** |
| | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **67,747.1** | **68,528.2** | **49,996.3** | **45,958.0** | **(4,038.3)** |
| | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ | 51,957.9 | 54,394.9 | 39,678.7 | 37,409.9 | (2,268.8) |
| | Цалин хөлс болон нэмэгдэл | 32,797.4 | 34,538.6 | 25,540.3 | 24,659.1 | (881.2) |
| | Ажил олгогчоос нийгмийн | 3,607.7 | 4,177.3 | 3,095.2 | 3,002.8 | (92.4) |
| | Байр ашиглалттай холбоотой | 5,433.3 | 6,689.8 | 4,222.7 | 3,898.8 | (323.9) |
| | Хангамж, бараа материалын | 1,292.5 | 1,214.5 | 925.3 | 823.9 | (101.4) |
| | Нормативт зардал | 3,283.5 | 3,284.7 | 2,188.0 | 1,785.4 | (402.6) |
| | Эд хогшил, урсгал засварын | 960.3 | 505.1 | 467.6 | 409.8 | (57.8) |
| | Томилолт, зочны зардал | 230.2 | 209.3 | 160.2 | 125.7 | (34.5) |
| | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,512.2** | **1,475.8** | **1,250.2** | **1,041.3** | **(208.9)** |
| | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,491.2 | 1,425.9 | 1,201.9 | 1,009.8 | (192.1) |
| | Аудит баталгаажуулалт, зэрэглэл | 1.4 | 9.4 | 9.4 | 10.6 | 1.2 |
| | Даатгалын үйлчилгээ | 5.6 | 17.2 | 16.9 | 9.5 | (7.4) |
| | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 9.5 | 12.4 | 12.4 | 8.9 | (3.5) |
| | Мэдээлэл,технологийн үйлчилгээ | 1.8 | 6.2 | 5.6 | 1.3 | (4.3) |
| | Газрын төлбөр | 2.3 | 3.4 | 2.7 | 1.0 | (1.7) |
| | Банк, СБ-ын үйлчилгээний хураамж | 0.4 | 1.3 | 1.3 | 0.2 | (1.1) |
| | Улсын мэдээллийн маягт хэвлэх | | | | | |
| | **Бараа үйлчилгээний бусад** | **2,840.8** | **2,299.8** | **1,829.2** | **1,663.1** | **(166.1)** |
| | Бараа үйлчилгээний бусад | 2,543.6 | 1,957.4 | 1,551.5 | 1,492.2 | |
| | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 297.2 | 342.4 | 277.7 | 170.9 | |
| | **ХҮҮ** | - | | - | - | - |
| | Гадаад зээлийн үйлчилгээний | | | | | - |
| | Дотоод зээлийн үйлчилгээний | | | | | - |
| | **ТАТААС** | 116.1 | 260.7 | 189.1 | 158.6 | (30.5) |
| | Төрийн өмчит байгууллагад | - | | | | - |
| | Хувийн хэвшлийн байгууллагад | 116.1 | 260.7 | 189.1 | 158.6 | (30.5) |
| | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **15,673.1** | **13,872.6** | **10,128.5** | **8,389.5** | **(1,739.0)** |
| | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 158.3 | 203.2 | 169.6 | 149.4 | (20.2) |
| | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 158.3 | 203.2 | 169.6 | 149.4 | |
| | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | | | | |
| | **Бусад урсгал шилжүүлэг** | **15,514.8** | **13,669.4** | **9,958.9** | **8,240.1** | **(1,718.8)** |
| | Нийгмийн даатгалын тэтгэвэр, | | | | | |
| | Нийгмийн халамжийн тэтгэвэр, | 9,670.0 | 10,323.2 | 7,406.5 | 6,278.0 | |
| | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж,урамшуулал | 340.6 | 102.8 | 100.8 | 50.7 | |
| | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,013.1 | 1,102.5 | 747.1 | 624.9 | |
| | ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | | | | | |
| | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 1,165.7 | 797.8 | 676.0 | 450.0 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан АХ-д олгох | 2,070.6 | 975.9 | 915.3 | 805.4 | |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,254.8 | 367.2 | 113.2 | 31.1 | |
| **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **4,553.9** | **7,196.4** | **6,177.0** | **5,020.0** | - |
| Барилга байгууламж | **1,207.3** | **2,006.1** | **1,808.8** | **1,538.1** | |
| Их засвар | **864.9** | **2,427.2** | **2,412.2** | **2,143.3** | |
| Тоног төхөөрөмж | **78.2** | **170.9** | **165.9** | **97.1** | |
| Бусад хөрөнгө | **2,403.5** | **2,592.2** | **1,790.1** | **1,241.5** | |
| Стратегийн нөөц хөрөнгө | | | | | |
| **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **2,173.8** | **3,133.3** | **2,915.8** | **1,277.3** | (1,638.5) |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ** | **23,967.1** | **78,857.9** | **48,257.4** | **48,061.4** | (196.0) |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | **64,204.4** | **36,444.2** | **36,248.2** | (196.0) |
| Улсын төсвөөс санхүүжих | | 14,123.7 | | | - |
| Засгийн газрын тусгай | | | | | - |
| Тусгай зориулалтын | 45,239.9 | **45,706.5** | 33,115.1 | 33,065.2 | (49.9) |
| Орон нутгийн хөгжлийн | 2,253.9 | **4,374.2** | 3,329.1 | 3,183.0 | (146.1) |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС** | **23,967.1** | **14,653.5** | **11,813.2** | **11,813.2** | - |
| Орон нутгийн төсвөөс | 23,967.1 | 14,653.5 | 11,813.2 | 11,813.2 | - |
| Орон нутгийн хөгжлийн | | | - | | - |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | | - | - | - |
| **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | - | | | | - |
| **БУСАД ЭХ ҮҮСВЭР** | | | | | - |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 166.0 | 163.0 | 163.0 | - | (163.0) |
| Төсвийн байгууллага | 157.0 | 157.0 | 157.0 | - | (157.0) |
| Төсвөөс гадуур байгууллага | 9.0 | 6.0 | 6.0 | - | (6.0) |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 3,914.5 | 4,051.5 | 4,051.5 | - | (4,051.5) |
| Удирдах ажилтан | 314.0 | 319.0 | 319.0 | - | (319.0) |
| Гүйцэтгэх ажилтан | 2,516.5 | 2,584.5 | 2,584.5 | - | (2,584.5) |
| Үйлчлэх ажилтан | 1,001.0 | 1,094.0 | 1,094.0 | - | (1,094.0) |
| Гэрээт ажилтан | 83.0 | 54.0 | 54.0 | - | (54.0) |
| **СУРАЛЦАГЧДЫН ТОО ( жилийн** | 28,411.0 | 29,732.0 | 29,732.0 | - | (29,732.0) |
| Ерөнхий боловсролын сургуульд | 21,362.0 | 20,681.0 | 20,681.0 | - | (20,681.0) |
| СӨБ байгууллагад суралцагч | 7,049.0 | 9,051.0 | 9,051.0 | - | (9,051.0) |

Нэгтгэж гаргасан: ТАБ-ын ажилтны ____________

Хянасан: Тэргүүлэх аудитор ____________

Аудитын менежер ____________

ОНТГ-Хавсралт №4

**Өвөрхангай аймгийн 2018 оны орон тоо, цалингийн сангийн судалгаа**

Дээд шатны байгууллага: ______________________

/сая.төг/

| № | Байгууллагын нэр | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | | | Ажил олгогчоос нийгмийн даатгалд | | | | Ажиллагсдын тоо | | | | | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өмнөх оны гүйцэтгэл | 2018 оны | | | Өмнөх оны гүйцэтгэл | 2018 оны | | | Өмнөх оны гүйцэтгэл | 2018 оны | | | | | | |
| | | | | | | | | | | | | | Үүнээс: | | | | |
| | | | Төсөв | Гүйцэтгэл | Зөрүү | | Төсөв | Гүйцэтгэл | Зөрүү | | Төсөв | Гүйцэтгэл | Үдирдах | Гүйцэтгэх | Үйлчлэх | Гэрээт | |
| А | Б | 1 | 2 | 3 | 4=3-2 | 5 | 6 | 7 | 8=7-6 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| 1 | **Улсын төсвийн байгууллага** | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | | |
| 2 | **Орон нутгийн төсвийн байгууллага** | 32,797.4 | 34,538.6 | 24,659.1 | (9,879.50) | 3,607.7 | 3,607.7 | 3,002.8 | (604.90) | 3,914.0 | 4051 | 4051 | 319 | 2584 | 1094 | 54 | |
| | | | | | | | | | | | | | | | | | |

Судалгаа гаргасан: Аудитор ____ Б.Эрдэнэцэцэг
/албан тушаал/ /гарын үсэг/ /ажилтны нэр/

Хянасан: Менежер ____ Д.Гансүх
/албан тушаал/ /гарын үсэг/ /ажилтны нэр/

Хянаж, хүлээн авсан: ТАБ, ажилтан
/албан тушаал/ /гарын үсэг/ /ажилтны нэр/

6217143681
ИЮА0059 9044094